# Гэрийн ухаалаг систем

**Орон зай цаг хугацаанаас үл хамааран хаана ч таны гэр таны хажууд байх болно.**




- -Ямарч утасгүй ажилдаг учраас айл гэрт суурьлуулахад маш хялбар.
- -Нарийвчилсан утасгүй технологи ,тэргүүлэх зэргийн RF кабель.
- -AES шифрлэлтийн технологи, таатай нөхцөл байдал болон хяналт.
- -Автомажуулалтын системд таны оролцоо шаардлагүй.

# Програм хангамж

iOS

Android

**Таблет PC, андройд, ios үйлдлийн системүүд дээр ажиллана.**

- Ашиглахад амархан
- Модуль тус бүрээр удирдах
- Нэг үйлдлээр бүгдийг удирдана

Хэрэглэхэд хялбар

Боломжит функцүүд

Удирдлагын товчлуур

Функцүүдийн харагдах байдал




## Горим удирдлага

**Хэрэглэгч олон төрлийн горим үүсгэн ганц товчлуураар тухайн горимд хамаарах үйлдлүүдийг гүйцэтгэнэ.**

Босох
Унтах

# Зочины өрөө

*Ухаалаг гэрийн түлхүүргүй нэвтрэх систем нь танд цоо шинэ мэдрэмж туршлага өгөх болно.*
*Хаалга нээгдэх, хаагдах үед хөгжим, гэрэл, агааржуулагч зэрэг бусад төхөөрөмжүүдийг асч унтарах үйлдлүүдийг утсаараа хийж болно.*

*Хэрэв та гэртээ орох бол "Home" гэсэн горимд гэрийн удирдлагыг шилжүүлсэнээр гэрэл асах, цахилгаан залгагдах, хөгжим эгшиглэх зэрэг үйлдлүүд автоматаар хийгдэх болно.*
*Гэрээс гарахдаа "Away" горимд шилжүүлсэнээр дээрх төхөөрөмжүүд унтарч хамгаалалтын систем ажиллаж эхлэнэ.*

*Зочин хонх дарахад утасны програмаар камертай холбогдон ирсэн зочины дүрсийг харан ярилцаж мөн утсаараа гэрийн хаалга онгойлгон өгч болно.*
*Гэр дотор байрлах аль ч камертай холбогдон гэрээ бүрэн хянах боломжтой.*

*Хамгаалалтын систем ажиллаж байх үед гэмт этгээд халдахад гэрэл асах, аваарын дуу гарган халдагчийн хөөх болно.*

# Унтлагын өрөө

*Гал гарах, хэн нэгэн тамхи татах зэрэг гэнэтийн аюулаас урьдчилан сэргийлж илгээх болно. Давхар даатгал нь таны амьдралыг илүү аюулгүй, найдвартай болгоно.*

*Өмнө нь бид гэр ахуйн хэрэгсэлүүдийг янз бүрийн аргаар удирддаг байсан бол ухаалаг гэрийн систем нь удирдлагуудыг таны гарт нэгтгэж өгнө. Гэрэл, ТВ, хөгжим, хөшиг, агааржуулагч зэрэг та утсаараа удирдаж болно.*

*Агаарын чанарыг тодорхойлно. Та агааржуулагчаа ажиллуулах цэвэр цэнгэг агаарыг мэдэрнэ.*

# Галын өрөө

Гал тогооны цахилгаан хэрэгсэл зэрэг төхөөрөмжүүдийг удирдсанаар та хэрэгслүүдээ тус тусад нь асааж унтраажудирдаж болно. Эрчим хүч хэмнэж, аюулгүй байдлыг хангах болно.

Гэр бүлийн зоог, найз нөхдийн хүлээн авалт үдэшлэг, романтик орчин зэрэгт тохируулах танхимын гэрэл гэрэлтүүлгийг тухайн үур амьсгалт тохируулж болно.

Байгалийн хий, ил гал дээр хоол унд цай бэлдэх нь илүү амттай болгох боловч гал алдах аюултай. Ухаалаг гэрийн мэдрэгчүүд нь шатамхай хий, утаа, температурын өөрчлөлт зэргийг илрүүлж аюулын түвшинд хүрэх үед дохиолол асааж дуу гарган танд мэдэгдэх болно.

# Унтлагын өрөө

Агаарын чанарыг тодорхойлж агааржуулагчийг тогтоож өгсөн цагаар автоматаар ажиллуулж таны тав тухтай амрах орчинг бүрдүүлнэ.

Та хүссэн үүр амьсгалдаа таарууулан гэрлийн унтрааж асааж, тодруулж бүдэгрүүлж тохируулж болно. Мөн та лед гэрэл ашигласнаар эрчим хүч хэмнэх боломжтой.

Цахилгаан унтраалгыг ашигласнаар хүссэн төхөөрөмжөө асааж, унтрааж удирдаж болно.

Утсаа ашигласнаар та хөшигөө илүү амарханаар удирдах болно.

# Угаалгын өрөө

Таны гэр бүлийн настай хүн, хүүхэд гэнэт бие нь муудах ч юмуу ямар нэгэн яаралтай тохиолдолд аваарын товчлуурыг дарсанаар гэрт гэрэл асах, дохиолол ажиллаж дуу гарна. Энэ нь урьдчилан сэргийлэх арга хэмжээ болно.

Гэртээ байх үед байхгүй үед ус алдах аюулыг цаг тухайд нь танд мэдэгдэх болно.

# *Гадаа талбай, цэцэрлэг*

*Гэрэл мэдрэгч нь орчины гэрлийг тодорхойлон гадаа гэрэлтүүлгүүдийг тохируулан асааж унтраана. Энэ нь эрчим хүч цаг хугацааг хэмнэнэ.*

*Хөдөлгөөн мэдрэгч нь болзошгүй аюул, гэнэтийн халдлагаас сэргийлнэ.*

*Усжуулалтыг та хүссэн үедээ утаснаасаа удирдах болно. Мөн тохируулсан цагаар ажиллах боломжтой.*

**Галын дохиолол.**

Утаа мэдрэгч нь болзошгүй аюулыг мэдээлж, арга хэмжээ авах боломжийг олгодог учир амь нас, эрүүд мэнд, эд хөрөнгийн хохирлоос урьдчилан сэргийлнэ.

**Ус мэдрэгч.**

Ус алдах аюулаас сэргийлснээр өөрт болон бусдад эд хөрөнгийн хохирол учируулахаас сэргийлнэ. Байгаль орчиноо хамгаалъя

**Усжуулалт**

Усжуулалтын системийн удирдах болон бороо орох мэдрэгч

**Температур**

**Өрөөний температур болон нүүрсхүчлийн хий, бусад хорт бодисуудыг хэмжинэ.**

**Хөдөлгөөн мэдрэгч**

Зөвшөөрөлгүй нэвтрэх, халдах үйлдлийг илрүүлж, өрөөнд орох үед гэрэл асч автоматжуулалтын систем ажиллах болно.